



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Өдөрлөг зохион байгуулах
тухай

Монгол Улсын “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 17.1.1, 17.1.7 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Засаг даргын 2012 оны 09 дүгээр сарын 14 ны өдрийн А/564 тоот захирамжийн 4 дахь заалтын хүрээнд Агаарын бохирдлыг бууруулах талаар Нийслэлийн төр захиргааны байгууллагаас хийгдэж буй ажлыг иргэдэд сурталчилах, шилдэг тэргүүний техник технологийг танилцуулах өдөрлөгийг Сүхбаатарын талбайд зохион байгуулахыг нийт ажилтнуудад даалгасугай.

2. Уг өдөрлөгийн арга хэмжээнд шаардагдах 23,200,000 /хорин гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /П.Ариунаа/-т зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж зохион байгуулж ажиллахыг ахлах мэргэжилтэн Ц.Цолмон, албаны нийт мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН